

“Шинжлэх ухааны үзэл санааны гол хэмжүүр бол сэтгэлгээг тэлэн судалгааны шинэ санааг нээж өгдөг”

Паул А.М.Дайрэк - физикч



GERMAN - MONGOLIAN INSTITUTE
FOR RESOURCES AND TECHNOLOGY

GMIT Campus, 2nd khoroo, Nalaikh district, Ulaanbaatar
Phone: +976 7023 2086
admission@gmit.edu.mn
www.gmit.edu.mn

The development of GMIT and its cooperation with German Partner universities is supported by the Mongolian Ministry of Education and Science, and the Federal Government of Germany. The German contribution to GMIT is implemented by the Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) and the German Academic Exchange Service (DAAD).

МГТИС-ийн хөгжил болон Германы хамтрагч их дээд сургуулиудын хамтын ажиллагаа зэргийг хоёр улсын Засгийн газар дэмжин ажилладаг. Монгол Улсаас БШУЯ болон Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ) болон Германы эрдмийн солилцооны алба (DAAD)-наас хариуцан, хэрэгжүүлэгч байгууллагаар ажиллаж байна.

To apply, visit our registration page for step-by-step application instructions:
<http://www.gmit.edu.mn/registration.html>

Thank you.



БОЛОВСРОЛ,
ШИНЖЛЭХ УХААНЫ
ЯАМ



германы
хамтын ажиллагаа
DEUTSCHE ZUSAMMENARBEIT

Implemented by

giz Deutsche Gesellschaft
für Internationale
Zusammenarbeit (GIZ) GmbH



DAAD
Deutscher Akademischer Austauschdienst
German Academic Exchange Service



GERMAN - MONGOLIAN INSTITUTE
FOR RESOURCES AND TECHNOLOGY

Энэхүү бүтээгдэхүүнийг байгальд ээлтэй, эко-друзлив дүрвэгч
paper-ийг ашигласан байна.



GMIT RESEARCH AND LABORATORIES - МГТИС-ИЙН СУДАЛГАА БА ЛАБОРАТОРИ



“The measure of greatness in a scientific idea is the extent to which it stimulates thought and opens up new lines of research.”

Paul A.M. Dirac – Physicist

As a model university, the German-Mongolian Institute for Resources and Technology (GMIT) has a strong focus on the integration of applied research and teaching. GMIT's academic staff members are actively involved in research projects with various industry partners as well as universities and research organizations in Mongolia, the Asian region and beyond. The professors of GMIT are renowned experts in their field and enjoy a world-class reputation for their contributions to leading international conferences and journals. Currently our faculty and students are conducting a wide range of research projects, for instance:

- Air Quality and Environmental Impact Assessment of Industrial Activities in Asian Region;
- Study on Algorithmic Development for Quasi-variational Inequalities related to Dynamic Systems;
- Establishment of PM2.5 pollution Baseline for Nalaikh district;
- Airborne spectral detection of Reusable Industry Materials in Tailings Facilities;
- Advanced Curriculum on Energy Efficient Buildings in Extreme Continental and Sunny Climate;
- Testing of advanced ESP systems;
- Online condition monitoring and diagnostics of rotor faults of industrial induction motors;
- Investigation of Leaching Behavior of Selected Coal;
- Evaluation of electrochemical techniques for the quantification of glue in copper electroplating electrolytes.



Монгол-Германы хамтарсан ашигт малтмал, технологийн их сургууль (МГТИС) нь загвар сургууль болохын хувьд хэрэглээний судалгааг сургалттай уялдуулахад ихээхэн анхаарал хандуулдаг. МГТИС-ийн багш, эрдэм шинжилгээний ажилтнууд нь аж үйлдвэрийн түнш, Монгол төдийгүй Азийн бүс нутаг, гадны орнуудын их, дээд сургууль, эрдэм шинжилгээний байгууллагуудтай хамтран судалгааны төсөл хэрэгжүүлэхэд идэвхтэй оролцож ажилладаг. МГТИС-ийн профессорууд нь салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн нэр хүндтэй мэргэжилтнүүд бөгөөд олон улсын түвшний хурал, сэтгүүлд оруулсан хувь нэмрээрээ дэлхийн түвшинд үнэлэгддэг нь тус сургуулийн бахархал юм. МГТИС-д хэрэгжиж буй судалгааны төслүүдээс дурдвал:

- Азийн бүс нутаг дахь үйлдвэрлэлийн үйл ажиллагааны агаар, орчны нөлөөллийг тооцох;
- Квази вариацийн тэнцэтгэл бишийн хувьд динамик системтэй холбогдох алгоритмын судалгаа;
- Нийслэлийн Налайх дүүргийн агаарын бохирдлын түвшин;
- Баяжуулах үйлдвэрийн хаягдлын аж ахуйгаас дахин ашиглагдах боломжтой үйлдвэрлэлийн материалыг агаараас тандан судлах замаар илрүүлэх;
- Ахисан түвшний ESP системийн туршилт судалгаа;
- Үйлдвэрийн цахилгаан хөдөлгүүрийн роторын гэмтлийг үл задлах аргын оношилгоо;
- Сонгосон нүүрсийг уусган баяжуулах түүний баяжигдах чанарыг судлах нь;
- Зэс ангижруулах электролизийн уусмалд цавуулаг бодисын хэмжээг электрохимийн аргаар тодорхойлох нь.

Why is it relevant to you that GMIT faculties are involved in research?

- **Top researchers are top teachers:** Our faculty members carry their passion for research into the classroom and are inspirational teachers. Those who do research can explain study subjects much better to students - especially when it comes to more advanced modules and topics.
- **No boring lectures:** Our faculty members include recent research discoveries in their classes. This makes classes more lively and exciting than teaching out of textbooks.
- **Internationally renowned scientists:** Our faculty members receive academic recognition for their research work; for example, publications in distinguished scientific journals or participation in domestic and international conferences.
- **Research university:** Research takes place on campus, with numerous possibilities for students to be involved. Moreover, GMIT organizes workshops and international conferences, bringing some of the world's leading scientists to Mongolia.
- **Student involvement:** At GMIT, students play an active role in research. Solving real-world problems and participating in research projects is inspiring and motivating for students. All study programs contain some student research. The M.Sc. study program in Resources and Technology is even fully research-oriented.

МГТИС-ийн багш, судлаачидтай хамтран судалгаанд оролцох нь танд ямар ач холбогдолтой вэ?

- **Сайн судлаач сайн багш байдаг:** Манай багш, судлаачид эрдэм шинжилгээний ажилд дурлаж оролцдог. Судлаач хүн ахисан түвшний хичээл, сэдвүүдийн талаар оюутнуудад илүү сайн тайлбарлаж чаддаг.
- **Лекцийг сонирхолтой явуулахад анхаардаг:** Багш нар хичээлдээ сүүлийн үеийн судалгааны үр дүнгээс оруулдаг нь хичээлийг сурах бичигтэй ажиллахаас илүү сонирхолтой, бодит болгодог.
- **Олон улсад хүлээн зөвшөөрөгдсөн судлаачидтай:** МГТИС-ийн багш нар судалгааны ажлаараа салбартаа хүлээн зөвшөөрөгдсөн төдийгүй, судалгааны өгүүлээ дотоодын болон олон улсын нэр хүндтэй сэтгүүллүүдэд хэвлүүлж, эрдэм шинжилгээний хуралд илтгэл хэлэлцүүлдэг.
- **Судалгаанд суурилсан их сургууль:** Тус их сургуульд явагдаж буй туршилт, судалгааны ажилд оюутнууд оролцох боломж нээлттэй. Түүнчлэн МГТИС нь нэр хүндтэй эрдэмтэн, судлаачдыг оролцуулсан семинар, олон улсын хурлыг тогтмол зохион байгуулдаг.
- **Оюутнуудын идэвх, оролцоонд анхаардаг:** Оюутнуудыг судалгааны ажилд идэвхтэй оролцуулдаг нь бодит асуудлыг шийдвэрлэх, тэдэнд судалгааны ажилд оролцох урам зоригийг өгдөг. Сургалтын хөтөлбөрт оюутны төсөл мөн багтана. “Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр нь судалгаанд бүрэн суурилсан.

Master (M.Sc.) in Resources and Technology

GMIT offers a research-oriented and unique postgraduate program, the Master (M.Sc.) in Resources and Technology. This study program is divided into three equally important parts: 1) core modules (with a focus on research methods for engineers and scientists), 2) electives (allowing a wide range of specializations), and 3) practical research. The skills and knowledge attained in this postgraduate degree program ideally prepare graduates for employment in research and development.

Join a research-oriented university like GMIT. Take the right decision.

In the recent past, GMIT has been successful in acquiring research projects funded by the Mongolian government and industry as well as international funding sources (e.g. from Germany and South Korea). Moreover, supported by Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit (GIZ), GMIT has established a Strategic Research Development Fund (SRDF).

GMIT's research projects deal with a wide range of topics, ranging from the basic sciences (e.g. mathematics) to the solution of practical problems, e.g. improved processing of raw materials, efficient energy production and use, intelligent monitoring of machines and the protection of the environment. A specific focus is on Resources and Technology – a field that also forms the core of GMIT's new research-oriented M.Sc. program and a PhD program that is currently under development.

Joining GMIT offers you a world-class education in engineering and science – and exciting opportunities to become involved in research.



“Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын хөтөлбөр

МГТИС нь судалгаанд суурилсан, “Байгалийн нөөц, технологи”-ийн шинжлэх ухааны магистрын ахисан түвшний хөтөлбөрийг санал болгож байна. Энэхүү сургалтын хөтөлбөр нь заавал судлах хичээлүүд (инженерийн болон шинжлэх ухааны судалгааны арга зүйд чиглэсэн), сонгон судлах хичээлүүд (мэргэшүүлэх чиглэлээс хамаарсан), практиктай уялдсан судалгаа гэсэн гурван чухал хэсэгт хуваагддаг. Түүнчлэн уг хөтөлбөрийн хүрээнд олж авсан мэдлэг, ур чадвар нь төгсөгчдийг судалгаа, хөгжүүлэлтийн салбарт мэргэжлээрээ амжилттай ажиллах боломжийг олгоно.

Судалгаанд суурилсан их сургууль болохоор зорин ажиллаж буй МГТИС-д элсэн суралцахыг урьж байна

Сүүлийн жилүүдэд МГТИС Монгол Улсын Засгийн газар, аж үйлдвэр, олон улсын байгууллагын санхүүжилттэй судалгааны төслүүдийг амжилттай хэрэгжүүлж байна. Мөн тус их сургууль нь Германы олон улсын хамтын ажиллагааны нийгэмлэг (Deutsche Gesellschaft für Internationale Zusammenarbeit)-ийн дэмжлэгтэйгээр Стратегийн хөгжлийн судалгааны санг байгуулсан.

МГТИС-ийн судалгааны төслүүд нь суурь шинжлэх ухаанаас эхлээд практик асуудлыг шийдвэрлэхээс гадна түүхий эдийн боловсруулалтыг сайжруулах, эрчим хүчний үр ашигтай үйлдвэрлэл болон ашиглалт, машин механизмын ухаалаг хяналтын систем болон хүрээлэн буй орчныг хамгаалах зэрэг сэдвийг хамардаг. “Байгалийн нөөц, технологи”-ийн чиглэлд онцгой анхаарал хандуулж буйн илрэл нь МГТИС-ийн шинжлэх ухааны магистрын шинэ хөтөлбөр болохоос гадна цаашид докторын сургалтын хөтөлбөрийг санал болгохоор ажиллаж байна.

МГТИС-д элссэнээр шинжлэх ухаан, инженерийн чиглэлээр дэлхийн түвшний боловсрол эзэмшихээс гадна судалгааны ажилд гар бие оролцох боломж бүрэн нээлттэй.

